

Миний биеийн аюулгүйн дүрэм

Миний бие бол миний л бие. Надаас өөр хэн ч эзэмшихгүй!

Би тэврүүлмээргүй, үнсүүлмээргүй байвал ҮГҮЙ! гэж хэлж чадна
Харин оронд нь би тэдэнтэй дохих, алгаа цохих, гар барьж, эсхүл ойр
дотнынхонтойгоо агаарын үнсэлт үлээн мэндэлж болно.
Би өөрийнхөө биеийн эзэн нь учраас яахаа би өөрөө л мэднэ.



Надад Итгэлийн Сүлжээ бий!

Надад Итгэлийн Сүлжээ бий!
Хүн болгоны Итгэлийн Сүлжээ өөр өөр байдаг Энэ сүлжээ
бол миний итгэлтэй том хүмүүс. Надад ямар нэг зүйл
тохиолдсон бол тэд нар маань надад заавал итгэнэ.
Хэрэв би ямар нэг зүйлд санаа зовсон, айсан эсхүл
итгэлгүй болсон бол өөрийнхөө Итгэлийн Сүлжээнд
байгаа хүмүүсийнхээ хэн нэгэнд нь хэрхэн,
яагаад ингээд байгаагаа хэлж чадна.



Түгшүүрийн шинжүүд

Хэрвээ би айж, аюултай байдлыг мэдэрвэл
хөлөрч, гэдэс эвгүйрхэж, чичирж, зүрх
маань түргэн цохилж магадгүй.
Энэ мэдрэмжүүдийг Түгшүүрийн
шинжүүд гэдэг.
Хэрэв би ямар нэг зүйлийн талаар энэ
мэдрэмжүүдийн аль нэгийг мэдэрвэл энэ
тухайгаа Итгэлийн Сүлжээнийхээ итгэлт том
хүндээ шууд хэлнэ.



Нууц.

Надад муухай, тавгүй мэдрэмж төрүүлсэн
ямар ч нууцыг би хэзээ ч хадгалахгүй.
Хэрэв хэн нэгэн хүн надад тийм нууцыг
хадгалахыг гуйвал...
Би энэ тухай Итгэлийн Сүлжээнийхээ
итгэлт том хүндээ түргэхэн хэлнэ.



Биеийн эмзэг хэсгүүд.

Миний дотуур хувцасны дотор багтдаг биеийн
хэсэг бол миний биеийн эмзэг хэсгүүд юм.
Би биеийнхээ эмзэг хэсгүүдийг бүгдийг
нь зөв нэрээр нь нэрлэдэг.
Хэн ч миний биеийн эмзэг хэсэгт хүрж болохгүй.
Хэн ч намайг өөрсдийнхөө биеийн эмзэг
хэсэгт хүрэхийг гуйж болохгүй.
Бас хэн ч надад биеийн эмзэг хэсгийг харуулсан
зураг үзүүлж болохгүй.
Хэрэв тэгвэл би энэ тухай итгэлийн сүлжээнийхээ
итгэлт хүндээ шууд хэлнэ.

